

ПРАГМАТИЗМ: 90-ЭЭД ОНЫ МОНГОЛЫН ГАДААД БОДЛОГЫН ҮНДЭС

Г. Төмөрчулуун*

Аливаа гадаад бодлого өөрөө туйлын зорилго бус, харин тодорхой зорилгод хүрэх арга мөн. Тэр тодорхой зорилго гэдэг бол үндэсний эрх ашиг юм. Монголын үндэсний эрх ашиг нь хоорондоо нягт уялдаатай гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: үндэсний аюулгүй байдал, үндэсний хөгжил, үндэсний сэргэн мандал.¹

Үндэсний эрх ашгаа хамгаалахын тулд дипломат үйл ажиллагаа дөрвөн зорилтыг шийдвэрлэх ёстой. Эхлээд Монголчууд бид өөрсдөө хэн бэ гэдгээ нарийн тодорхойлох явдал. Үүнд түүх, соёл шашны уламжлал, газар зүй, цаг уур, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн байдал, геополитикийн онцлог, гадаад хүрээлэлтэйгээ хэрхэн яаж харьцаж ирсэн, одоо яаж харьцаж байгаа зэрэг цогц асуудал орно. Дараа нь харьцах улсаа буюу олон улсын байгууллагаа үүх түүхээс нь аваад өнөөг хүртэл сайн мэдэх ёстой. Гол нь тухайн улс юуг хүсч эрмэлзэж ямар санаа зорилго, сонирхолтойг нь мэдэх нь чухал. Гуравт, Монгол, тухайн улс хоёрын хүсэл эрмэлзэл, сонирхол юунд нийцэж, юугаараа зөрж байгааг олж тогтоох ёстой. Хамгийн сүүлд уг сонирхлын нийцэл, зөрөлдөөнд үндэслэн өөрийн бодлогыг тодорхойлно.

Бодлого, чиг шугамаа ийнхүү тодорхойлсоны дараа (өнөөгийн шатанд бол Монгол дахь хоосон зайг бөглүүлэх) түүнийг хэрэгжүүлэх бодлогын хувилбарыг олох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, энд гадаад бодлогын боломжийн хувилбаруудын тухай яригдаж байна. Нэгэнт тодорхойлсон зорилгоо чухам гадаад бодлогын ямар хувилбараар хэрэгжүүлэх вэ? Хэд хэдэн хувилбарыг авч үзье.

1. ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Томас Хоббс хэлэхдээ хүн хүндээ чоно байдаг гэдэг зарчим олон улсын харилцаанд ч үйлчилдэг гэсэн нь буй.² Конрад Лоренц хүн бүүр эхээс төрөхдөө түрэмгий шинжийг өөртөө шингээсэн байдаг.³ Иймд тодорхой хүмүүсээр удирдуулдаг улс орнууд хоорондоо дайсагнаж бие биенийгээ түрэмгийлж байдаг гэжээ. Кеннет Вольц дэлхийн хаан, дэлхийн засгийн газар гэж байдаггүй. Иймд олон улсын харилцаа анарх байдалтай байх тул ертөнцөд дайн дажин тасрахгүй гэсэн нь буй.⁴

Эндээс үүдэн улс орнууд гагцхүү өөрийгөө л бодох ёстой гэсэн үзэл газар авч, түүнийг Английн улс төрийн зүтгэлтэн Лорд Пальмерстон тун онож дүгнэсэн байдаг. «Англи улсад мөнхийн дайсан ч байхгүй мөнхийн анд ч байхгүй. Түүнд гагцхүү мөнхийн эрх ашиг л бий» гэж тэр хэлжээ.⁵ Энэ томъёоллыг Америкийн реалист сургуулийн эцэг гэгддэг Ханс Моргентау гүнзгийрүүлж «Америкийн гадаад бодлого цорын ганц бурхантай. Тэр бол Америкийн үндэсний эрх ашиг мөн» гэжээ.

Орчин үеийн олон улсын хуулийн эцэг гэгддэг Уго Гроций улс хоорондын харилцаанд гагцхүү хуулийг дээдлэх ёстой гэж үзэж байсан бол Германы аугаа их гүн ухаантай Имануэль Кант олон улсын харилцаанд хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг удирдлага болгох ёстой бөгөөд дэлхийн улс орнууд хоорондоо «Мөнхийн энх тайван»-ы гэрээ байгуулах ёстой гэж үзэж байжээ.

Өөрөөр хэлбэл, хүчээр түрээ барих бодлогын төлөөлөгчид буюу (Хоббс, Пальмерстон, Бисмарк, Талейран, Черчилль, Вольц, Морген-

тау, Жорж Кенан, Хэнри Киссенжер, Збигнев Бжежинский) реалист сургууль, олон улсын хуулийг дээдлэхийг уриалагчид буюу Уго Гроций, Стэнли Хоффман, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг шүтэхийг уриалагчид (Кант) буюу либерал сургууль гэсэн гурван үндсэн сургууль Өрнөдөд үүсэж өнөөг хүртэл хөгжиж иржээ. Яг өнөөдрийн байдлаар эл гурван сургууль гурвуул зэрэгцэн оршиж байгаа боловч сүүлийн 2 сургууль нь давамгайлах байдалтай байна. Энэ нь олон улсын хамтын нийгэмлэгийн дунд хууль сахиулах үндсэн үүрэг хүлээсэн НҮБ-ын үүрэг роль нэмэгдэж буй, ардчилал, хүний эрх, эрх чөлөө зэрэг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг дээдлэх хандлага улам бүр эрч хүчээ авч байгаагаар илэрч байна. Энэ утгаараа бидний дэлхий ертөнц аажмаар Гроций-Кантын дэлхий ертөнц болохнээ гэж ойлгогдож байна. Гадаад, дотоод бодлогын асуудал тусгагдсан байдлаас нь авч үзвэл манай шинэ үндсэн хууль ч Гроций-Кантын үндсэн хууль гэхэд хилсдэхгүй.

Олон улсын эдийн засгийн харилцаанд бас л 3 сургууль, зонхилж ирсэн.⁶ Энэ нь реалист (националист), либерал, марксист сургууль юм.

Товчоор хэлбэл реалист сургуулийнхны хувьд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал бол хамгийн эрхэм зүйл байдаг. Ийм эдийн засгийн аливаа үйл ажиллагаа тусгаар тогтнолоо хамгаалах гэсэн туйлын зорилгод захирагдах ёстой гэж үздэг. Дотоодын зах зээлээ хамгаалах, импортын барааны татварыг нэмэх, худалдааны блокууд байгуулах зэрэг бодлого үүнд хамаарна. АНУ, ЕЭЗХН-ийн орнуудын хоорондын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний талаарх зөрөлдөөн ч энэ онолын практик илрэл юм. Харин либерал сургуулийнхан (Адам Смитийн талынхан) тусгаар тогтнол гэсэн улс төрийн зорилгыг бус ард түмний сайн сайхан амьдралыг дээшлүүлэх гэсэн эдийн засгийн зорилтыг буюу эдийн засгийн харилцан хамаарлыг гол болгодог. Либерал эдийн засагчдын хувьд улс төр, эдийн засгийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаар гэх мэтийн ойлголт байдаггүй. Бүх зүйл эдийн засгийн хуулиар шийдэгдэнэ гэж үздэг. Иймд тэдний хувьд бие даасан улс гэдэг ойлголт байдаггүй. Учир нь тэд дэлхийг бие даасан улсуудын нийлбэр гэхээсээ эдийн засгийн нэг цогц орон зай гэж үзэж бараа, үйлчилгээ хүмүүсийг чөлөөтэй солилцох ёстой гэдэг.

Хоёр онолын аль аль нь сайн, муу хоёр талтай. Реалист сургуулийн онолоор явбал зожигрох, ганцаардах аюулд орж мэднэ, либерал онолоор явъя гэвэл бусдын нөлөөнд хэт орох аюул байна. Ухаалаг бодлого энэ хоёрын зааг дээр буюу зөв хослуулахад л байгаа болов уу. Тэгэхдээ ертөнцийн хөгжлийн хэтийн төлөв либерал онолын талд буйг үргэлж бодох нь зөв.

Дээрхээс үзвэл улс төрийн бодлогод ч эдийн засгийн гадаад харилцааны бодлогод ч реалист, либерал хоёр сургуулийг зөв хослуулах нь Монголын хувьд онц чухал бөгөөд ийм прагматик чиг баримжаа «төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх»⁷ тухай үндсэн хуулийн заалтад нийцэх юм.

2. ПРАКТИК БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД

Дэлхийн улс гүрнүүд үндсэндээ гурван төрлийн гадаад бодлого явуулж иржээ. Үүнд:

1. Их гүрний гадаад бодлого
2. Төвийг сахисан гадаад бодлого
3. Үл нэгдэх гадаад бодлого болой

Эхний хоёр нь гадаад улс төрийн бодлогын хоёр туйлшрал буюу нэг нь «глобализм», нөгөө нь «изоляциялизм» юм.

1. ИХ ГҮРНИЙ ГАДААД БОДЛОГО

Энэ бодлого нь улс гүрнүүд бий болсон цагаас хойш байсан бөгөөд дэлхийг нөлөөний хүрээний дагуу хуваан захирах тодорхой орон, бүс нутагт нөлөө, ноёрхлоо тогтооход чиглэж иржээ. Өнөөгийн их гүрний гадаад бодлого улам бүр эдийн засагт тулгуурлах болж байна.

2. ТӨВИЙГ САХИХ ГАДААД БОДЛОГО

Гадаад бодлогын нөгөө туйл буюу төвийг сахисан гадаад бодлого гэдэг нь мөн чанартаа «хувиа хичээж, довоо шарлуулах» бодлого болой. Практик гадаад бодлогын талаас нь авч үзвэл 1816 оноос Швейцар улс анх ийм бодлого тунхаглажээ.

2.1 Европ тив ба төвийг сахих бодлого

Өнөөдөр төвийг сахих бодлогыг Швейцарь, Австри, Финлянд зэрэг Европ тивийн орнууд явуулж байна.

Де-юре төвийг сахихын үндсэн нөхцөл бол хүчтэй эдийн засаг, аюулгүй байдлаа хангах цэргийн хангалттай хүч чадал, тэр бодлогыг хүндэтгэхэд чиглэсэн олон улсын эрхийн баталгаа юм. Өөрөөр хэлбэл төвийг сахих асуудал дотоод, гадаад хоёр талтай.

Дээр нэр дурдсан төвийг сахисан орнууд хөгжлийнхөө түвшин, батлан хамгаалах чадвараараа Европт дээгүүр байранд орно.

Төвийг сахисан статус нь энэхүү статусыг хүндэтгэсэн олон улсын эрх зүйн баталгааг шаардана. Энэ нь уг асуудлын гадаад тал нь юм. Ийм баталгаагүйгээр нэг талын үндсэн дээр төвийг сахих бодлого зарлан тунхаглах нь тухайн улсын үндэсний эрх ашигт аюул учруулж болзошгүй юм. Гэтэл баталгаа олж авах асуудал туйлын төвөгтэй (жишээ нь Балба, Энэтхэг) болой. Өнөөгийн олон улсын практикт үүнийг батлах баримт олон буй. 1990 онд Унгарын парламентад төвийг сахих бодлогын асуудлаар халуун маргаан явагдах, чухамдаа тийм баталгаа байхгүйгээс болж унгарчууд төвийг сахих санаанаасаа ухарчээ. Харин Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны үйл явцад идэвхтэй оролцох замаар улс орны аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж тэд үзжээ.

Нөгөө талаар хүйтэн дайн дууссан, цэргийн хүчин зүйл буурсан өнөөдрийн өндөрлөгөөс авч үзвэл төвийг сахих бодлого улам бүр явцгүй болж байна. Энэ нь төвийг сахих бодлого өнөөгийн интеграцчлагдах үйл явцад харшлах болсонтой холбоотой. Австри, Финланди, Швейцарь алс хэтээ бодож үндэсний эрх ашиг, нийтийн жишгийг дагаж тухайлбал Европын хамтын нийгэмлэгт орохыг эрмэлзэх болов. Гэтэл төвийг сахисан статус нь саад болж түүнээсээ татгалзах байдалд өөрийн эрхгүй орж байна. Нэг үгээр хэлбэл, Европ тивд интеграцчлах үйл явц эрчимжих тусам төвийг сахих бодлогын ач холбогдол улам буурах хандлага зонхилох болов.

2.2. Төвийг сахих бодлого ба Ази тив

Ази тив Европоос эрс ялгаатай. Энэ бүс нутагт тодорхой улс орон тэр ч бүү хэл бүхэл бүтэн салбар бүс нутаг өөрийгөө төвийг сахих юм уу цөмийн зэвсэггүй бүс гэж зарлаад үр дүнд хүрч байсан баримт өнөөг хүртэл гараагүй юм. Ийм байдлын үндсэн шалтгаан нь гол төлөв гадаад хүчин зүйл, тухайлбал их гүрнүүд баталгаа гаргахаас дургүйцдэгт оршино. Дөчөөд оны сүүлээр төвийг сахих бодлого тунхаглаад дараа нь татгалзсан Энэтхэг, тавиад онд мөн ийм бодлого тунхаглаад хэрэгжүүлж чадалгүй өдий хүрсэн Балба, 1962 оны Лаосын оролдлого бүүр сүүлд Камбодж, Афганистаны зэрэг олон жишээ татаж болох юм.

Салбар бүс нутгийн тухайд гэвэл Зүүн өмнөд Азийг төвийг сахи-

сан бүс болгох тухай АСЕАН-ы санал, Номхон далайн өмнөд хэсгийг цөмийн зэвсэггүй бүс болгох Паротонгийн гэрээ мөн л дээрхийн нэгэн адил бэрхшээлтэй тулгарчээ.

Дээрхийг дүгнэвэл ямар бодлого явуулах нь, тухайн тодорхой улс бүс нутгийн эрх мэдлийн хэрэг боловч гадаад хүчин зүйл, дэлхийн хөгжлийн хандлага, их гүрнүүдийн ашиг сонирхлыг заавал харгалзан үзэх хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

2.3. Монгол ба де-юре төвийг сахих бодлого

Юуны өмнө, дээр тэмдэглэсэнчлэн де-юре төвийг сахих бодлогын материаллаг үздэс болох эдийн засгийн хүч чадал манайд алга байна. Түүнчлэн хүчтэй эдийн засагт дүйцсэн хүчтэй арми алга байна. Үүн дээр гадаад хүчин зүйлийг нэмж бодолцох ахул төвийг сахих дотоод, гадаад нөхцөлийн аль аль нь алга байна гэсэн дүгнэлт гарч байна.

Ази тивийн онцлог байдлаас үүдэн энэ бүс нутагт төвийг сахих гэсэн оролдлого их гүрнүүдийн зүгээс дэмжлэг олж байгаагүй туршлагыг ч бодолцох нь зүйтэй.

Нөгөөтэйгүүр хөрш хоёр улсаа харж «жижигэрхэх» ёсгүй. Дэлхий ертөнцийн хөгжлийн ерөнхий хандлагыг заавал бодолцох ёстой. Гэтэл тэр үндсэн хандлага нь улс орнууд төвийг сахиж туйлшрахад бус бүх талаараа нээлттэй байж XXI зууны дэлхий дахины болон Ази, Номхон далайн ардчилал, шударга ёс, эдийн засаг технологийн их интеграцид нэгдэн нийлэхэд оршино. Монгол улс энэ үйл явцаас хоцрох бус тэр лүү тэмүүлж бусад улс түмэнтэй зуузай холбон алхах явдал юм. Өөрөөр хэлбэл, нээлттэй бодлогод хаалт хэрэггүй. Байнга төвийг сахина гэдэг бол өөрийн үйл ажиллагаанд өөрөө хязгаарлалт тавина гэсэн үг. Харин гадаад бодлогын тодорхой асуудлаар ад-хок төвийг сахисан байр суурь баримтлах тийм тохиолдол гарч болох талтай.

3. ҮЛ НЭГДЭХ БОДЛОГО

Улс төрийн гадаад бодлогын дээр дурдсан гурван хэлбэрийн сүүлчийн хэлбэр нь үл нэгдэх бодлого юм. Энэ бодлого «глобалист» буюу их гүрний, «изоляциянист» буюу төвийг сахих бодлогын хооронд чөлөөтэй хөдлөх боломж олгодог уян хатан бодлого юм. Үл нэгдэх бодлого нь «глобалист» төвийг сахих бодлогын аль алины нь элементүүдийг оруулдаг. Тухайлбал, үл нэгдэх бодлогын эцэг гэгддэг Энэтхэг Өмнөд Азийн хэмжээнд «глобалист» үйл ажиллагаа явуулж байхад Мальта улс үл нэгдэх, төвийг сахих хоёр статусыг хослуулж хэрэглэж байх жишээтэй (Энэ хоёр статус бие биеэ үгүйсгэх бус харин харилцан нөхдөгийг Мальтын жишээ харуулж байна).

Гадаад бодлогод өргөн эрх чөлөө олгодог утгаараа үл нэгдэх бодлого дэлхийн хамгийн их тархсан бодлого болой. НҮБ-ын гишүүдийн дөрөвний гурав нь буюу дэлхийн 108 улс ийм бодлоготой. Тэд бүгд хөгжиж байгаа орнууд бөгөөд үл нэгдэх бодлого бол мөн чанартаа хөгжиж буй орнуудын гадаад бодлого юм. Үл нэгдэх бодлого явуулна гэх мөртлөө нэгдэх бодлого явуулдаг ч улс бий.

Үл нэгдэх бодлого хэдийгээр ерөнхий зарчмууд, хэм хэмжээнд (нутаг дэвсгэртээ гадаадын цэргийн баазгүй байх, их гүрнүүдийн сөргөлдөөнд оролцохгүй байх, хоёр олон талын цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байх г.м) тулгуурладаг боловч олон өнгө аястай байдаг. Энэ өнгө аяс нь улс орнуудын геополитик, үзэл суртал, эдийн засгийн өвөрмөц онцлогоос урган гардаг. Энэ утгаараа үл нэгдэх гадаад бодлогын 108 (гишүүн орнуудын тоогоор) хувилбар байна гэж үзэх үндэстэй. Жишээ нь үл нэгдэх бодлого явуулдаг Куба улс тэр бодлогоо АНУ-ын эсрэг чиглүүлж байхад мөн тийм бодлого явуулдаг Сингапур,

Пакистан, Чили, Саудын Араб АНУ-тай ойртох зорилгодоо ашиглаж байдаг. Энэтхэгийн үл нэгдэх бодлого аль нэг хэмжээгээр Хятадын эсрэг өнгө аястай байхад Балба, Пакистаны үл нэгдэх бодлого Энэтхэгийн эсрэг чиглэсэн байх жишээтэй. Индонез, Малайз, Сингапур зэрэг шинээр үйлдвэржсэн орнуудын үл нэгдэх бодлого эдийн засгийн асуудалд голлон чиглэж байдаг.

Төвийг сахих бодлогын нэгэн адил үл нэгдэх бодлогын ач холбогдол ч өнөө үед эрс буурав. Энэ нь мөн л олон улсын харилцаанд гарч буй өөрчлөлтүүдтэй холбоотой.

3. 1. Монгол ба үл нэгдэх бодлого

«Хоёр дэх ертөнц» буюу хуучин социалист гэгдэж байсан ч орнуудад болсон хувьсгалын дараа «үл нэгдэх» бодлого ч явцгүй болж байгаа юм бол Монголд яагаад үл нэгдэх бодлого хэрэгтэй юм бэ? Энд хэд хэдэн хүчин зүйл буй. Үл нэгдэх бодлого бол Монголын хувьд, ялангуяа шилжилтийн үед хөрш хоёр оронтой тэнцвэртэй харилцахад сэтгэл зүйн нэг тулгуур болж буй.⁸ Энэ хэрэгт онолын хувьд 100 гаруй улсын дэмжлэг авна гэсэн үг.

Монгол өөрөө хөгжиж байгаа орон тул хөгжиж буй орнуудын бодлогыг нэг бүрчлэн дагадаггүй юм аа гэхэд тэдэнтэй ямар нэг хэмжээгээр эв санааны нэгдэлтэй байх шаардлагатай. Нөгөөтэйгүүр үл нэгдэх бодлого гадаад харилцаанд чөлөөтэй хөдлөх эрх чөлөө, өөрөөр хэлбэл харьцангуй бие даасан бодлого явуулах боломж олгодог.

Үл нэгдэх бодлогоос өөртөө хэрэгтэй түүний эрх ашигт нийцсэн тийм л зүйлүүдийг нь Монгол авах ёстой. Тийм зүйлүүдийн тоонд дээр дурдсан 3 үндэслэл юуны өмнө хамаарна.

4. «ЗАРЧИМЧ» ГАДААД БОДЛОГО

Дээр нэгэнт тэмдэглэсэнчлэн олон улсын харилцааны онол, практикт зарчим буюу олон улсын эрх зүйн чухал үүрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Олон улсын харилцаанд үзэл суртлын гүйцэтгэх үүрэг буурч, ялангуяа НҮБ-ын үүрэг «хүйтэн дайны» үеийнхтэй харьцуулахад эрс нэмэгдэв. Энэ нь Монгол шиг бага буурай орны хувьд аюулгүй байдлаа хамгаалах гэдэг утгаараа онц чухал.

Гэхдээ олон улсын эрх бүх өвчнийг эмнэдэг шидэт эм биш ээ. Хэдэн жишээ хэлье. Бүрэн эрхт байдал халдашгүй дархан гэж олон улсын хуульд заасан нь буй. Өнөөдөр бүрэн эрхт байдал улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарлаас үүдэн огт халдашгүй дархан зүйл байхаа нэгэнт болив. Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх нь улс хоорондын харилцааны ариун шүтээн саяхан хүртэл байлаа. Энэ зарчмын дагуу Югослав улс холбооны нэгдсэн улс хэвээрээ л байх байсан. Улс орнууд ч үүнийг хүндлэх ёстой байлаа. Гэтэл тэгсэнгүй, Югослав задардгаараа задарлаа. Дотоод хэрэгт үл оролцох тухай зарчим байна. АНУ Японыг зах зээлээ нээсэнгүй гэж шүүмжилдэг, хариуд нь төсвийн алдагдлаа арилгасангүй, америкчууд залхуу, америкийн бараа өрсөлдөх чадвар муутай гэх мэтээр япончууд Америкийг шүүмжилдэг. Үүнийг америкчууд Японы, Япон Америкийн дотоод хэрэгт орж байна гэхээс өөрөөр нэрлэхээс аргагүй. Хүний эрхийн асуудал байна. Иракийн курдууд, Балтийн гурван улс дахь оросуудын асуудал нь дан ганц Ирак юм уу, Балтийн гурван улсын дотоод хэрэг биш угтаа олон улсын шинжтэй асуудал юм. Өөртөө засан тохинох эрх гэж бий. Гэтэл өнөөдөр Хятадын Түвд юм уу Өвөр монгол. Оросын Тува, Буриад, уг эрхээ хэрэгжүүлэе гэвэл Хятад, орос хоёр юу гэж үзэх юм бэ? Испанийн Баск. Канадын Квебек бас л ийм байдалтай.

Ингэхлээр олон улсын эрх зүй улс хоорондын асар их нарийн,

ээдрээ төвөгтэй бүх асуудлыг шийдвэрлэх цорын ганц хэрэгсэл хараахан биш бололтой. Иймд түүнд сохроор итгэх нь учир дутагдалтай.

Дээрхээс үндэслэн дүгнэхэд, Монгол дээрх бодлогын хувилбаруудаас өөрийн эрх ашигт нийцсэн тэр л зүйлүүдээс авч ашиглана. Төвийг сахих бодлогоос ад-хок төвийг сахих хэлбэрийг, үл нэгдэх бодлогоос хоёр хөрштэй тогтоосон харилцааг тэнцвэржүүлж бусад их гүрнүүдийн эрх ашгийг Монголд оруулахад дөхөм үзүүлэх тэр хүчин зүйлийг нь авах, олон улсын эрх Монголд чухал боловч түүнийг улс орнууд хэрэггүй гэж үзсэн үедээ огт хэрэгсдэггүйг бас бодолцвол зохилтой.

Харин өнөөгийн олон улсын харилцаа уламжлалт хоёр талын харилцаанаас олон талын харилцаанд шилжиж буйг үгүйсгэх аргагүй юм. Ийм харилцааны үндсийн үндэс нь олон улсын эрхэд тулгуурласан олон улсын байгууллагууд (бүсийн болон дэлхийн), олон улсын дэглэмүүд (сансрыг энх тайвны зорилгоор ашиглах, Антарктидийн дэглэм, Озоны давхаргын тухай, их далайн тухай, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх г.м) болой. Өөрөөр хэлбэл улс орнууд өөрийн тусгаар тогтнолд хамаарах асуудлуудыг олон улсын байгууллагууд, дэглэмүүдэд шилжүүлж эхэлсэн онцлогийг үргэлж бодолцож, энэ үйл явцад дэмжлэг үзүүлэх нь чухал юм.

5. ПРАГМАТИЗМ

Монгол улс прагматик бодлого явуулах нь Монголын онцлог, олон улсын харилцааны шилжилтийн энэ үед илүү нийцнэ. Энэ юу гэсэн үг вэ? гэхээр зарчим юм уу, алив үзэл суртлыг хатуу барьж, зууралдах бус зарим асуудлаар буулт хийж, зөвшилд хүрэх, түншийнхээ эрх ашгийг бодолцох, уян хатан байх, алдах, авахын тэнцлийг зөв хангах гэсэн үг юм. Хэдийгээр нэг асуудлаар алдавч, нөгөө асуудлаар олох орлого түүнээс ч илүү байж болно шүү дээ. Ийм прагматик бодлогын үндсийн үндэс нь Монголчууд бидний оюун ухаан, тодорхой хэлбэл, олон улсын аливаа үзэгдэл, үйл явдалд задлан шинжилгээ хийх, үндэсний эрх ашгийн үүднээс зөв дүгнэлт үнэлэлт өгөх чадвар юм.

Бидэнд Америкийнх шиг цэргийн хүч чадал бага. Японых шиг хүчтэй эдийн засаг алга, Хятадынх шиг тэрбум хүн ам алга. Тэгэхлээр хөлгүй их далайд хөвж яваа завь шиг бидэнд тийм чадвар амин чухал. Дүн шинжилгээ хийх чадвар бол аугаа их хүч юм. Орчин үеийн олон улсын харилцааг нэг цогц гэж үзэж, хэрэгтэйг нь хэрэггүйгээс салгаж, үндэсний эрх ашгийг шууд болон шууд бусаар хөндөж болох бүх элементийг цогцолбороор харж, түүнд үндэслэн бодлогоо төлөвлөж хэрэгжүүлэх нь нэн чухал. Чингэснээр бид олон улсын харилцаанд сүүл барьж, урсгалаар нь хөвөх бус, түүний чиг хандлагыг урдаас харж, түүнд өөрийгөө бэлтгэж, олон улсын хамтын нийгэмлэгт олж авсан байр сууриа бэхжүүлж чадна.

ЗҮҮЛТ

1. Г. Төмөрчулуун. «Тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг ба үндэсний аюулгүй байдал 1991 оны 8 дугаар сарын 10, 18-ны дугаарт
2. S. Kim, *The Lorenzian Thoery of Aggression and Peace Research: A Critique. The War Sustum. An Interdisciplinary Approach.* p. 82. Westview press Boulder, Colorado, 1980
3. *Also Why People Fight in the Causes and Prevention of War* by Seyom Brown St. Martin's Press New York, 1987, p. 9--10
4. Hedley Bull. *The anarchical sosiety: A study of order in world politics* (London, Makmillian, 1977) p. 87
5. Lord Palmerston, in the debate on the treaty of Adrianople, Harvard, 3-rd series vol 18, Col. 122
6. Энэ гурван сургуулийн тухай харьцуулсан, хамгийн тодорхой ойлголтыг Роберт Жилпиний номоос үзэж болно. Robert Gilpin, *The political economy of international relations.* Princeton University Press, Princeton, New Fersey 1987. pp. 25—64.
7. Монгол улсын үндсэн хууль, Улаанбаатар. 1992 он. Оршил х, 3
8. Тумурчулуун Г. Политика МНР в отношении движения неприсоединения. (1961—1990 гг) Диссертация на соискания ученой степени к.и.н. 1990 г. Дипломатическая Академия МИД СССР. 1990 г (Дви жения неприсоединения служит дак раз тем механизмом, через который можно будет согласовать интересы трех сторон (Монголии, России и Китая). В этом отношении движение неприсоединения выступает в качестве политического катализатора интересов СССР и КНР по отношению в Монголии. Неприсоединившаяся Монголия будет исходить в своих отношениях с двумя соседями из не каких-то идеологических стереотипов, а из объективных факторов определяющих её национальные интересы ... стр 29)